

**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ДОТУУР БАЙРНЫ СТАНДАРТЫН
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН
УДИРДАМЖ**

Захиалагч: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Гүйцэтгэгч: Зөвлөх /1 хүн/

Хугацаа: 1 хүн/сар

Үндэслэл

2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар МБС-ын 84 байгууллага үйл ажиллагаа явуулж нийт 38526¹ суралцагч суралцаж байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 7.5 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд суралцагчдын 52 хувь нь 14-18 насны өсвөр үеийнхэн, залуучууд, 1.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын харъяанд нийт 66 дотуур байр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр дотуур байранд нийт 5 мянга гаруй хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучууд амьдарч байгаагийн 40 гаруй хувь нь эмэгтэйчүүд байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны 54.5 хувь нь хөдөө орон нутагт байрлаж байна. Эдгээр дотуур байранд дээрх 5 мянга гаруй хүүхэд, залуучуудын 70 орчим хувь амьдарч байна.

Сургууль, дотуур байрны орчинд суралцагчдыг аливаа болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, суралцагч бүрийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн дараах хэм хэмжээ, стандарт, шаардлагууд мөрдөгдөж байна. Тухайлбал, ерөнхий боловсролын сургуулиуд, дээд боловсролын байгууллагын оюутны дотуур байрны орчин, үйлчилгээний стандарт нь "Олон нийт иргэний барилга" /БНБД 31-03-03/, "Сургалт-хүмүүжлийн барилгын зураг төсөл зохиох нэгдсэн норм" /БНБД II-66-88/, "Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны барилгын төлөвлөлтийн элементүүдийн нормаль" /ТН-II-2.2-1985/, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм /Зам,

¹ Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын статистик мэдээлэл, ХНХЯ, 2019.

тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 305 дугаар тушаал/ зэрэг норматив баримт бичгийн хүрээнд хэрэгжиж байна.

Мөн Стандартчилал хэмжилзүйн үндэсний зөвлөлөөс “Оюутны дотуур байрын үйлчилгээний нэгдсэн стандарт”-ыг 2008 онд баталж 2010 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус стандартаар оюутны дотуур байрны үйлчилгээ, дотуур байрны өрөөний зохион байгуулалт, ариун цэврийн өрөө, номын сан, өрөөний цонхны стандартыг тогтоосон. Гэтэл мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны дийлэнх нь 30-40 жилийн өмнө ашиглалтад орсон, тодруулбал 74 хувь нь 30-аас дээш жилийн ашиглалттай, 2010 оноос зөвхөн 30 гаруй хувьд нь их засвар хийсэн, нийт дотуур байрны 17 хувь нь стандартын бус байна. Иймд “Оюутны дотуур байрын үйлчилгээний нэгдсэн стандарт”-ын хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй.

Түүнчлэн МХЕГ-ын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалаар баталсан “Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.31 дэх хэсэгт дотуур байран дахь сурагчдын болон ажилчдын бие засах газар, охидын эрүүл ахуйн кабины тоо, хэмжээ, харьцаа зэргийг тодорхой тусгасан хэдий ч мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны орчин, үйлчилгээн дэх хэрэгжилт тодорхойгүй, үнэлгээ хийх, үнэлгээнд суурилсан цаашид сайжруулах талаарх дүгнэлт, зөвлөмж чухал байна.

Үүнээс гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй 500 гаруй суралцагч суралцдаг тухай тоо мэдээ байна. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 256 дугаар тушаалын 6 дугаар хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм”-д тусгай сургууль, дотуур байрны 1 сурагчид ногдох эдэлбэр газрын хэмжээг хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрээр ялгавартай тогтоосон байдаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний орон зай, зам, шалны гадаргуу, авто зогсоол, орц гарц, шат, ариун цэврийн өрөө, бусад тоног төхөөрөмжийн шаардлагыг тодорхой тусгасан. МСҮТ-ийн харьяаны дотуур байрууд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучуудын эдгээр онцлог хэрэгцээ шаардлагыг хангаж буй эсэхэд мөн дүгнэлт шаардлагатай.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны үйлчилгээний чанарт тухайн ажил, үүргийг гүйцэтгэх хүний нөөцийн чадамж, чадавх чухал. Гэтэл мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны багш нарын 26 хувь нь багш бус мэргэжилтэй байгаа нь “дотуур байрны багш” гэсэн нийтлэг ойлголт, нэршлийг одоогоор нэгдсэн байдлаар тодорхойлоогүй, ажил үүргийн хуваарь, статус, хариуцлага тодорхойгүй байгаатай холбоотой.

Дотуур байрны орчин нөхцөл, багшлах боловсон хүчний эдгээр хүчин зүйлс нь дотуур байранд амьдарч буй хүүхэд, өсвөр үе, залуучуудын эрх зөрчигдөх, хөгжил, хамгаалал хангагдахгүй байх, дотуур байрны орчинд гэмт хэрэг, зөрчил гарах, үйлдэгдэх, хохирох эрсдэлийг үүсгэж байна.

Иймд холбогдох стандарт шаардлагыг боловсруулан батлуулах, улсын хэмжээнд дагаж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай байна.

Зорилго

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны үйлчилгээнд тавигдах шаардлага, стандартын төслийг залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагсдад ээлтэй, хүртээмжтэй, чанартай үйлчилгээ бүхий орчин нөхцлийг бүрдүүлэхэд чиглүүлэн боловсруулахад оршино.

Ажиллах хугацаа

2019 оны ... сарын ... өдрөөс ... сарын ... өдөр хүртэл 1 хүн/сар

Гүйцэтгэх ажлын хүрээ

Зөвлөхийн ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гэрээний хавсралтаар батлах бөгөөд дараах ажлыг тусгана. Үүнд:

1. Холбогдох газар, хэлтэс, сургалтын байгууллагуудаас шаардлагатай статистик тоо, мэдээ, мэдээлэл, хүчин төгөлдөр баримт бичгүүдийн хэрэгжилтийн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх;
2. Дотуур байруудад ажиллаж, үйлчилгээ, орчин нөхцөлтэй танилцах, тулгамдсан болон хэрэгцээт ажил, үйлчилгээний талаар багш, ажилтнууд, суралцагчдын оролцоог хангасан судалгааг хийх;
3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны стандартын төслийг боловсруулах;
4. Стандартын төслийг холбогдох талуудын оролцоог ханган хэлэлцүүлэх, саналыг тусган сайжруулах;
5. Стандартын төслийг эцэслэж ХНХЯ-нд хүлээлгэн өгөх.

Хүлээлгэн өгөх бүтээгдэхүүн

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны үйлчилгээнд тавигдах шаардлага, стандартын төслийг Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлж, хүлээлгэн өгнө.

Зөвлөхийн ур чадвар /сонгох шалгуур үзүүлэлтүүд/

1. Боловсрол:
 - 1.1 Хууль, эрх зүй, боловсрол, нийгмийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;
 - 1.2 Хүүхэд, өсвөр үе, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын асуудлаар мэргэшсэн;
2. Туршлага:
 - 2.1 Бодлогын баримт бичиг, стандарт боловсруулах, батлуулах чиглэлээр ажлын туршлагатай;
 - 2.2 Төрийн бодлого, үйл ажиллагаа, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх чадвартай;
 - 2.3 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад багш, нийгмийн ажилтнаар ажиллаж байсан туршлагатай байх;

- 2.4 Дотуур байранд амьдарч буй хүүхэд, өсвөр үе, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх чадвартай;
 - 2.5 Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар туршлагатай, мэдлэгтэй, онцлог талыг мэддэг бол давуу талтай;
 - 2.6 Дотуур байрны асуудлаар ажиллаж байсан туршлагатай бол давуу талтай;
 - 2.7 Дээр дурдсан чиглэлээр 5 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;
3. Хэлний ур чадвар:
- 3.1 Англи хэлийг мэргэжлийн чиглэлээр хэрэглэх түвшинд эзэмшсэн байх;
4. Мэргэжлийн ур чадвар:
- 4.1 Эрх зүйн баримт бичиг, MNS үндэсний стандарт боловсруулах;
 - 4.2 Баримт бичиг боловсруулахад шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ, тооцоог бие даан хийх, дүгнэлт гаргах;
 - 4.3 Баримт бичгийн төсөл хэлэлцүүлэхэд хамгаалах, батлуулахад нөлөөлөх;
 - 4.4 Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, удирдан чиглүүлэх;
 - 4.5 Компьютерийн хэрэглээний програмуудыг чөлөөтэй ашиглах;
 - 4.6 Богино хугацаанд, хурдтай, бие даан ажиллах, хувийн зохион байгуулалт сайтай байх;
 - 4.7 Холбогдох салбарт ашиг сонирхлын зөрчилгүй байх.

Бүрдүүлэх материал:

1. Уг ажлыг хийх сонирхлыг илэрхийлсэн хүсэлт;
2. Товч намтар;
3. Мэргэжил, мэргэшил, мэдлэгийг нотлохуйц баримтууд, үүнд диплом, сертификат, гэрчилгээний хуулбар;
4. Ажил гүйцэтгэх төлөвлөгөө

Хяналт, тайлагналт

- Зөвлөх нь явцын/эцсийн тайлан, бүтээгдэхүүн хүлээлгэн өгөх хугацаа зэргийг тусгасан ажлын календарчилсан төлөвлөгөөг боловсруулж гэрээнд хавсаргана.
- Мэргэжлийн хүмүүсийг оролцуулсан ажлын хэсгийн уулзалтад ХНХЯ, төрийн болон төрийн бус бусад байгууллагын оролцоог хангана.
- ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газар, Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүн амын хөгжлийн газрын Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн удирдлага, холбогдох ажилтнуудтай байнга холбоотой ажиллана.
- ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газар, Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүн амын хөгжлийн газрын Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн удирдлага, холбогдох ажилтнууднь зөвлөхийн ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавина.

Хугацаа

- Зөвлөх үйлчилгээний гэрээг 30 хоногийн хугацаатай байгуулна.
- Захиалагчид эцсийн бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгсөн хэдий ч бүтээгдэхүүний хэрэглээ, сайжруулалттай холбоотой асуудлаар зөвлөх нь шаардлагатай үед захиалагчтай хамтран ажиллана.

Санхүүжүүлэгч:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

- Зөвлөхийн гэрээний төлбөр 8.000.000 /найман сая/ төгрөг байна.
- Зөвлөхийн ажлын хүрээ, ажил үүргийн хуваарийг талууд тохиолцсоны үндсэн дээр гэрээний төлбөрийг 70/30 хуваарьтайгаар гэрээг байгуулна.
- Гэрээний төлбөрийн нийт дүнд хувь хүний орлогын албан татвар /гэрээний төлбөрийн 10 хувь/ багтсан болно.
- Захиалагчид эцсийн бүтээгдэхүүнийг бүрэн хүлээлгэн өгсний дараа гэрээний үлдэгдэл төлбөр болох 30 хувийг олгоно.

-oOo-